

Гэрлэлт, гэр бүлийг Бурхан томилдог

Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондох гэрлэлт

Судал.

Марк 10:6–9; 1 Коринт 11:11-ийг болон Залуу эмэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгч асан Бонни Л.Оскарсон эгчийн дараах мэдэгдлийг уншина уу. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондох гэрлэлтийн тухай сургаалыг олж мэд.



Судар бидэнд “Эзэн дотор эр хүнгүйгээр эм хүн гэж үгүй бөгөөд эм хүнгүйгээр эр хүн гэж үгүй юм” (1 Коринт 11:11) хэмээн заадаг. Эхнэр, нөхөр хоёр санваарын бүрэн байдлын адислалуудыг хүлээж авахын тулд Их Эзэний өргөөнд лацдан холбогдож, хамтдаа зөв шударгаар хөдөлмөрлөж, гэрээндээ үнэнч хэвээр үлдэх ёстой. Энэ бол үр хүүхдүүддээ зориулсан Их Эзэний төлөвлөгөө бөгөөд Түүний тунхагласан зүйлийг ямар ч олон нийтийн яриа, шүүмжлэл өөрчлөхгүй. . . . Өөр үзэл бодолтой хүмүүст хайр энэрэл, нинжин сэтгэлээ үзүүлэхийн зэрэгцээ Их Эзэний томилсноор гэрлэлтийн энэхүү жаягийн хамгаалагчид байцгаая. (Бонни Л.Оскарсон, “Гэр бүлийн тунхгийн хамгаалагчид,” 2015 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 132)

Ярилц.

- Эрэгтэй, эмэгтэй хүний хоорондын гэрлэлт “Бүтээгчийн хүүхдийнхээ мөнхийн хувь заяаны төлөөх төлөвлөгөөг” гүйцэлдүүлэхэд хэрхэн тусалдаг вэ? (“Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг,” ChurchofJesusChrist.org)
- Бид Аврагчийн эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондох гэрлэлтийн сургаалыг хамгаалахын сацуу өөр санаа бодолтой хүмүүст хэрхэн энэрэнгүй хандаж чадах вэ?

“Үржиж, олширцгоог! Газар дэлхийг дүүргэ”

Судал.

Эхлэл 1:27–28; Дуулал 127:3; Марк 10:13–14-ийг болон Арван хоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Нийл Л.Андэрсэны дараах мэдэгдлийг уншина уу. Хүүхдүүдийн талаар Их Эзэн юу гэж заасныг олж мэд.



Бид хүүхдийнхээ нүд рүү харахдаа мөнх бус байдлын өмнөх амьдралд бидэнтэй хамт байсан Бурханы хайрт хүү, охиныг олж хардаг.

Бурханы эдгээр сүнсэн хүүхдэд зуурдын бие махбодыг өвлүүлэн үлдээх онцгой эрх, боломж эхнэр, нөхрүүдэд байдаг. Бид гэр бүл, үр хүүхэдтэй байхад итгэдэг.

Гэр бүлд хүүхэд төрөхөд эхнэр, нөхөр хоёр нь хүүхдүүдийг дэлхийд авчрах Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөг биелүүлдэг. Их Эзэн “үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг хүмүүнд тохиолгон авчрах нь миний ажил мөн миний алдар суу бөлгөө” [Моше 1:39] хэмээн хэлсэн. Үхэшгүй байдлын өмнө зуурдын байдал гэж байх ёстой. (Нийл Л.Андэрсэн, “Хүүхдүүд,” 2011 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 33)

Ярилц.

- Хүүхдүүд болон гэр бүлийг мөнхийн ойлголтоор харах нь гэрлэсэн хосыг зарим шийдвэрээ чухалчилж үзэхэд хэрхэн тусалж болох вэ?
- Бид хүүхдүүдтэй хэрхэн харьцах, хандах талаар Аврагчийн үлгэр жишээнээс юу сурч чадах вэ?

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН
СҮМ